



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

179

2013 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох,  
түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11.2 дах заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 12 дугаар сарын 16-ны хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ионсей найрамдал эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 3 сараар түдгэлзүүлсүгэй.

2. Дурдсан хугацаанд МХЕГ-аас ирүүлсэн акт, албан шаардлагад дурдагдсан зөрчлүүдийг арилгах ажлыг зохион байгуулж ажиллахыг Ионсей найрамдал эмнэлгийн ерөнхий захиралд үүрэг болгосугай.

3. Дор нэр дурдсан аж ахуйн нэгжийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай. Үүнд:

1. Маконплюс ХХК – Эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох,
2. Хан судар ХХК - Эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох, худалдах,

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /А.Эрдэнэтуяа /-д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

003048